



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

Хяналт шалгалтын мөрөөр авах
арга хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.1.1.а, 4.5 дахь заалт, Улсын онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 1915 тоот албан бичгээр өгсөн чиглэлийг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хөдөлмөрийн тухай (шинэчилсэн найруулга) хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх болсон, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн “Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 141 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсон, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулах боломж бүрдсэнтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төрийн байгууллага, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдэд даалгасугай:

1.1.Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлгүй, сонгон шалгаруулалтгүйгээр, хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангаагүй томилогдсон албан хаагчийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон албан үүргээс нь чөлөөлөх;

1.2.Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн “Зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр зөвлөмжийн 2.2, 2.3-т заасны дагуу иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ, контрактын гэрээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгох, цаашид энэ үндэслэлээр гэрээ байгуулахгүй, сунгахгүй байх;

1.3.Энэ тогтоолын 1.1, 1.2-т заасан сул орон тооны мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлд харьяаллын дагуу хүргүүлэх, албан хаагчийн албан үүргийг хууль, журмын дагуу түр орлон гүйцэтгүүлэх;

1.4.Сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу нээлттэй зарлаж, хууль болон тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлагын тусгай шаардлагыг хангасан төрийн албан хаагч, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэн холбогдох журмын дагуу бүртгүүлэх,

21000974

сонгон шалгаруулалтад тэгш оролцох, нээлттэй өрсөлдөх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авах;

1.5.Шалгалтыг Улсын онцгой комиссоос зөвлөсний дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримталж, Эрүүл мэндийн яам болон мэргэжлийн байгууллагуудаас гаргасан заавар, зөвлөмжийг мөрдөж, мэдээлэл технологийн боломжийг ашиглан мэргэжлийн байгууллагын хяналтан дор зохион байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтийн мэдээллийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг төрийн байгууллага, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдэд даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Ц.Амартөгс)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ